

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 3 дугаар сарын 27-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-11

1.Монгол Улсын Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх
тухай асуудал

4-11

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 3 дугаар сарын 27-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 19 цаг 45 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Г.Уянгахишиг;
Чөлөөтэй: Ц.Даваасүрэн, Ч.Лодойсамбуу;
Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Номин, Б.Пүрэвдорж;
Тасалсан: Ж.Баярмаа, А.Ганбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан,
О.Цогтгэрэл, Ө.Шижир, Д.Энхтуяа.

Нэг.Монгол Улсын Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ танилцуулав.

Хүсэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Б.Хэрлэн нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт үг хэлэв.

Ц.Сандаг-Очир: Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатарыг өөрийн хүсэлтийг үндэслэн үүрэгт ажлаас нь чөлөөлье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	16
Татгалзсан:	3
Бүгд:	19

84.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир “Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатарыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 20 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 25 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр 20 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 3 дугаар сарын 27-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 19 цаг 45 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд танхимдаа ирье. Одоо нэг гишүүн дутуу байна. Ингээд ирц хүрчихлээ.

Байнгын хорооны ирц хүрсэн, хурлаа эхэлье. Байнгын хорооны ирцдээ орсон гишүүд хуралдааны танхимдаа орж ирэхийг урьж байна аа. Ирц 53.1 хувь хүрсэн.

Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ оройн амар амгаланг айлтгая аа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Байнгын хорооны хуралдаанд Дашзэвэгийн Амарбаясгалан, Аюушийн Ариунзаяа, Жадамбын Бат-Эрдэнэ, Батын Батбаатар, Жигжидийн Батжаргал, Баярмагнайн Баярбаатар, Сандагийн Бямбацогт, Лувсаннямын Гантөмөр, Сархадын Зулпхар, Цагаанхүүгийн Идэрбат, Лхагвын Мөнхбаатар, Нямтайширын Номтойбаяр, Эрдэнэбилигийн Одбаяр, Цэндийн Сандаг-Очир, Ням-Осорын Учрал, Бадарчийн Хэрлэн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна аа. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя аа.

Нэг асуудал хэлэлцэнэ. Монгол Улсын Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудал. Монгол Улсын Ерөнхий сайд 2026 оны 3 сарын 27-ны өдөр ирүүлсэн хүсэлт.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё Ерөнхий сайд орж ирсэн байна. Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар чөлөөлөгдөх хүсэлтээ танилцуулна аа.

Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг өгье. Занданшатар даргад.

Г.Занданшатар: Эрхэм байнгын хорооны дарга, Их Хурлын гишүүд ээ,

Дэлхий нийтийн өмнө тулгарсан нефтийн бүтээгдэхүүний хомсдол, үнийн өсөлтөөс шалтгаалсан эдийн засгийн хямралт байдалтай давхцуулсан улс төрийн гацаа түгжээнд төрийн ажлыг тасралтгүй явуулахад нэг өдөр, нэг минут ч гэсэн манай улсад байхгүй байна. Энэ хариуцлагатай үед бол улс орнууд өдөр, цаг алдалгүй хариу арга хэмжээ авч шуурхай ажиллах шаардлагатай байгаа. Ийм учраас энэхүү улс төржилтийн гацаанаас гарах нь миний үүрэг хэмээн ухамсарлан

эх орон ард түмнийхээ эрх ашгийг нэн тэргүүнд тавьж Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайдын албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж байна аа. Хүсэлтийг хүлээн авч Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Ц.Сандаг-Очир: Занданшатар даргад баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 100.3-д Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайдаас чөлөөлөгдөх шалтгаан, үндэслэлийн талаар гишүүд асуулт асууж үг хэлж болно гэж заасан. Ерөнхий сайдаас чөлөөлөгдөх хүсэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Нэрсээ өгье. Зулпхар гишүүн, Хэрлэн гишүүнээр тасаллаа Зулпхар гишүүн асуултаа асууя.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүд, Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарт оройн мэнд дэвшүүлье. Би их тодорхой асуулт асуух гэж байна л даа. Дөнгөж сарын өмнө Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар, Монгол Улсын нийгэм эдийн засгийн байдлын талаар бас мэдээлэл өгсөн олон нийтэд. Улс төрчид энэ талаар мэдээлэл авсан. Тэгээд энэ мэдээлэл дээрээс 2025 онд Монгол Улсын эдийн засаг 6.5 хувиар өссөн. Валютын нөөц 7 тэрбумд хүрсэн. Түүхэндээ анх удаа улсын төсвийг 2.3 их наядаар бид хэмнэж чадлаа. Цаашлаад бол төрийн албан хаагчдын тоог цөөхөн чадварлаг болгох энэ зорилтын хүрээнд 226 мянга байсныг нь 214 мянга болгож бид бас бууруулж чадлаа.

Нөгөөтээгүүр, нэн ялангуяа одоо жишээ нь сүүлийн жилүүдэд бол өсөлт огт жишээ нь гарахгүй байсан ХАА-н салбар дээр томоохон өсөлт бий боллоо. Цаашлаад Улсын Их Хурлаас 120 дугаар тогтоолыг баталсан. Энэ Оюу толгой төслөөс Монгол Улсын хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр энэ бид жишээ нь тогтоол гаргасан байгаа. Энэ тогтоолын хэрэгжилттэй уялдуулаад Рио Тинто компанитай хэлэлцээрийн ширээний ард суулаа. Тодорхой үр дүнгүүд гарч байна. Монгол Улсын хүртэх өгөөжийг бид нэмэгдүүлэхэд жишээ нь баттай зогсож байна гэсэн ийм мэдээллүүд авсан. Тэгэхлээр зэрэг асуулт 3 байна.

Нэгдүгээрт бол энэ амаргүй сорилтуудыг та давжээ. Тэгэхээр энийг хэрэгжүүлэхтэй холбоотой танай кабинет сайн ажиллаж байсан гэж үзэж байсан. Тэгэхээр энэ сайн ажиллаж байсан юм бол яагаад ийм шийдвэр гаргах болов оо гэдэг 1 дүгээр асуулт.

Энэ зүгээр нэгэнтээ эдийн засгийн нөхцөл байдал их тодорхой болчихлоо. Гаднын хямрал дотогшоо орж болохгүй учраас та бол би дотооддоо хямрал үүсгэхгүйн тулд энэ ажлаасаа бас чөлөөлөгдөж байна гэсэн бас тайлбар тавьж байх шиг байна. Тэгэхээр зэрэг энэ зүгээр цаашдаа бид энэ бий болсон сорилтуудыг давах чиглэлээр яаж ажиллах вэ гэдэг бас ийм асуулт байна. Энэ яагаад гэвэл дараагийн жишээ нь Ерөнхий сайд болох хүнд та бас тодорхой өөрийнхөө жишээ нь зөвлөгөөг өгөөд бас явах ёстой шүү дээ. Энэ чинь төрийн ажил тасралтгүй залгамж чанараа хадгалаад явах ёстой учраас. Тэгэхээр энэ талаар та бас өөрийнхөө байр суурийг илэрхийлээч гэж байна баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 3 номерын микрофон. Занданшатар дарга хариулна.

Г.Занданшатар: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Маш чухал асуулт байна. Өнөөдөр дэлхийн ер гаруй улсад шатахууны хомсдол нүүрлэж шатахууны онц байдал холбогдох хариу арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Одоо тэр дотроо бүүр онц байдал зарласан улсууд ч байна. Бангладеш гэх мэт. Нэн ялангуяа Азийн эдийн засагт ихээхэн сөргөөр нөл нөлөөлж энэ эрчим хүч шатахууны хямралаас үүдэлтэй дэлхийн эдийн засгийн хямрал үүдэж байна гэж дүгнэж байгаа. Үүнтэй холбогдуулаад улс орнууд шатахууны нөөцөө 600 сая тонн 400 сая тонн шатахууны нөөц гаргахад Япон, АНУ 170 сая стратегийн нөөцүүдээ ашиглахаас өгсүүлээд төрөл бүрийн багц арга хэмжээнүүдийг авч зарим улсад Солонгос, Бангладеш, Вьетнам олон улсуудад ажлын цагийг багасгах, 3 дахь өдрийг амралтын өдөр болгох хөдөлгөөн, зорчих хөдөлгөөнийг хязгаарлаж шатахууныг бага зарцуулах гэх мэтчилэн уриалга гаргаж онцгой нөхцөл байдлын зарим газар бүр онц байдал тогтоож ажиллаж байна.

Тийм учраас өдөр цаг болгон үнэтэй чухал. Монгол Улсын Засгийн газраас үүнтэй холбогдуулж импортын татварыг, шатахууны импортын татварыг бууруулах хуулийн төслийг өргөн бариад байна. Энэ маань хэлэлцэгдэхгүй байна. Улсын Их Хурал гацаанд байна. Засгийн газраас өөдрөг төсөөллөөр шатахууны үнэ 190 доллар хүрэх, муу төсөөлөл одоогийнхоороо хэвээр хадгалагдах 100 орчим долларт хадгалагдах өөдрөг төсөөлөл. Үүний үндсэндээ бараг 50 хувиар өсчхөөд байгаа энэ үнийн өсөлт иргэдийн амьдралд эдийн засагт бүтээгдэхүүний үнэд нөлөөлөл учруулж маш их дарамт учруулах учраас энийг хөнгөлөх чөлөөлөх 3 төрлийн арга хэмжээнд төлөвлөгөө боловсруулаад энийг хэрэгжүүлж эхэлж түрүүчээсээ Улсын Их Хуралд өргөн мэдүүлж чуулганаар бүлгийн хурлаар хэлэлцүүлэх зорилго тавин ажиллаж байгаа боловч энэ ажлууд маань үндсэндээ ингээд гацаанд ороод төрийн бүх түвшинд төрийн тасралтгүй ажиллагаа хангагдахгүй, эргэлзээтэй, тодорхой бус байдал үүсэж байгаа юм. Ийм учраас энэнээс нэг өдөр нэг минут ч гэсэн алдахгүйгээр бид хурдан шийдвэрлэж гарах гарц гаргалгаа нь энэ юм бол бид өөрийн хувийн болон улс төрийн эрх ашгийг хойш нь тавьж улс орны эрх ашгийг төрийн эрх ашгийг эн тэргүүнд тавьж энэнээс хамгийн хурдан шийдвэрлэх арга зам нь өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх явдал юм аа. Ингэвэл илүү зам нээгдэх юм байна гэж үзэж энэ шийдвэрийг гаргаж байгаа юм.

Тэгэхгүй бол бусад шийдлүүд бол намын дүрмээр ч юм уу бусад шийдлүүдээр 45-аас дээш хоног дотор шийдэгдэх шийдлүүд байна. 2, 3 долоо хоногоор хуулийн хугацаатай шийдлүүд байна. Ингэж хүлээх цаг хугацаа алга байна. Энэний үнийг ард түмэн төлөх болно. Бензин шатахууны үнэ, бүх үнэ ханшид нөлөөлнө. Өнөөдрийн ковидоос хойших үнийн өсөлт тэртээ тэргүй ард иргэдийн амьдралд хүнд дарамт учруулж байгаа. Бид бол тодорхой хатуу бодлогуудыг хэрэгжүүлсний үр дүнд эдийн засгийн өсөлт 6.5 биш 6.8, валютын нөөц 7 тэрбум доллар, 1 тэрбум долларын цэвэр ашигтай түүхэндээ анхаарч худалдааны эдийн засаг ашигтай гарч онцгой дэглэм рүү тогтоож, экспортыг нэмэгдүүлж, бодит үр дүн гаргаад энэ макро эдийн засгийн өсөлтийг айл өрх болгоны үүд хаалгаар орох 300 хоногийн төлөвлөгөө баталж ажиллаж байгаа. Энэ 300 хоногийн ажлын төлөвлөгөө дотор 104 арга хэмжээг нэг бүрчлэн төлөвлөж ажиллаж байгаа. Жишээлбэл зөвшөөрлийг хөнгөвчлөхөөс авхуулаад эдийн засгийн эрх чөлөөг олгох, чөлөөлөх, цэгцлэх цогц арга хэмжээнүүдэд үйлчилж байгаа. Энэ бүх ажил маань өөрөө төрийн ажлын энэ тасралтгүй тодорхойгүй байдлаас үүсээд төрийн бүх албаны түвшинд ч гэсэн ийм саатал хүлээлт бий болж байна. Энийг үргэлжлүүлж болохгүй, ингэвэл улс орны эдийн засаг нийт улсын эрх ашгийг хохирох учраас ийм шийдвэр гарч байгаа.

Ц.Сандаг-Очир: Зулпхар гишүүн нэг минут тодруулъя.

С.Зулпхар: Баярлалаа. Нэг зүйлийг бас тодорхой болгож асууя гэж бодож байна л даа. Яах вэ энэ нефтийн хямрал бол үндсэндээ 2 дахь удаагийн том нефтийн хямрал болж байна. 1974 онд Араб Израилын мөргөлдөөн бас яг ийм байдлыг бий болгож байсан. Энэ удаад Израил, Ираны мөргөлдөөн энэ нөхцөл байдлыг бий болгочихлоо шүү дээ. Тухайн үед яах вэ ЗХУ байж байж энэ хямралыг давсан бусад нөхцөлүүд байсан байх. Одоо бидний хувьд ОХУ гэж том хөрш байна. Эрчим хүч нефтийн газрын томоохон нөөцтэй улс орон шүү дээ. Бид урт хугацааны бас хэлэлцээртэй ийм улсууд.

Тэгэхээр та Ерөнхий сайд байх хугацаандаа энэ чиглэлээр тодорхой бэлтгэлүүдийг хангаад явсан уу. Дараагийн Ерөнхий сайдад энэ бэлтгэл шууд дамжигдаад хэрэгжих боломж байгаа юу гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Занданшатар дарга нэг минутад хариулъя.

Г.Занданшатар: ОХУ-ын Засгийн газартай хийсэн яриа хэлэлцээний үр дүнд бид АИ-92 бензиний үнийг 15-аар хямдруулж тогтворжуулж явж байгаа. Энэ бол мөрдөгдөнө АИ-92 бензиний үнэ өсөхгүйгээр үнийн санал яваад байна. Бас өнгөрсөн онд ОХУ-д хийсэн айлчлалуудын үр дүнгээр нефть бүтээгдэхүүний хангамж тогтворжсон, тогтворжилт, хангамж баталгаатай, тогтвортой байна. Бид үнийг тогтворжуулах санал Мишүстин Ерөнхий сайдад захидал бичсэн. Ер нь бол ОХУ бид хэдий хүнд нөхцөлд байгаад ч гэсэн ямар ч тохиолдолд нефть бүтээгдэхүүний хангамжийг тасалдуулахгүй. Харин зах зээлийн үнийн жишгээ дагаж мэдээж үнэ ханш өөрчлөгдөнө. Одоогоор авч байгаа үнийн саналууд өндөр ирээд байгаа. Энийг бид аль болох зөөлөн газардуулах бодлого стратегийг барьж байна. Энэ чиглэлээр ААН-ийн, импортын, НӨАТ-ын шатахуун бүтээгдэхүүний татваруудыг хөнгөлөх чөлөөлөх тийм бодлогууд гаргасан байгаа юм. Ингэж байж зөөлөн газардахгүй бол нефть бүтээгдэхүүний үнэ өсөх нь бүх.

Ц.Сандаг-Очир: Хэрлэн гишүүн асуултаа асууя.

Б.Хэрлэн: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Тэгэхээр би 2 зүйлийг тодруулж асууя гэж бодож байна. Тэгэхээр та 10 сарын хугацаанд Ерөнхий сайдаар ажиллалаа. Таны авч хэрэгжүүлж байгаа бодлого дотроос Монгол хүн баялагтаа, байгалийн баялагтаа эзэн болох тухай дээр та нэлээн сэтгэл тавьж ажилласан гэж харагддаг. Стратегийн орд газруудын өгөөжийн 65 хувийг нь 4, 5 ордоос тийм ээ, Ухаа худаг, Ачит эх, Цагаан суваргын асуудал яасан юм байгаа юм? Эд нарын өгөөжийн 65 хувийг үндэсний баялгийнхаа санд хуримтлуулах тухай та ийм шийдвэр гаргаж байсан танай Засгийн газар. Ингээд Оюу Толгойн хэлэлцээр явагдаж байгаа. Ид явагдаж байгаа. Зээлийн хүүг бууруулах тухай удирдлагын зардлыг нь бууруулах тухай нэлээн дорвитой бас ийм хэлэлцээрийг хийгээд явж байгаа. Саяхан бас сошиалд ил тавьсан мэдээллээр болоод ирэхээр ашигласан усанд нь татвар ноогдуулаад явах шийдвэр гаргасан гээд яригдаж байсан.

Тэгэхээр ер нь энэ ашигт малтмал уул уурхайтай ингээд холбоотой асуудал яриад ирэх үед Монгол Улсын Засгийн газар хэд хэдэн Засгийн газар ерөнхийдөө ингээд л огцроод явж байсан л даа. Сошиалаар ч гэсэн яг ингэж шуугьж байна. Тэгэхээр та энэ байгалийн баялагтаа Монголын ард түмэн эзэн байх тухай та

өөрийнхөө эхлүүлсэн энэ үйл хэргээ ер нь цаашдаа үргэлжлүүлэх тухай дээр та ямар бодолтой байгаа вэ гэж би 1 дүгээрт асуумаар байна.

Хоёрдугаарт нь 2020-2024 оны Улсын Их Хурлын даргаар та ажиллаж байсан. Тэр үед ард түмэн хууль тогтоох, хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд оролцдог болгох, нийтийн өргөдлийн механизм гэдгийг та нэвтрүүлсэн. 100 мянган хүн гарын үсэг зурах юм бол хууль санаачлах, 70 мянган хүн гарын үсэг зурах юм бол хяналт шалгалтыг хийх, 33 мянган хүн гарын үсэг зурах юм бол ажлын хэсэг тодорхой асуудлаар байгуулаад ингээд явах. Өөрөөр хэлэх юм төр барихад ард түмэн оролцох. Жинхэнэ ардчиллыг хэрэгжүүлэхэд та маш том үзэл санааны хувьд бас маш том дорвитой ийм механизмыг нэвтрүүлж оруулж ирж том өөрчлөлтийг хийсэн.

Тэгэхээр сая 10 сард Ерөнхий сайдаар ажиллах хугацаандаа яг энэ ардчиллыг хамгаалах, ард түмэн төр засгаа барихад гар бие оролцох энэ арга механизмуудаа хэрэглэж байв уу? Энийг цаашдаа ер нь төрийн үйл хэрэгт ялангуяа энэ хууль тогтоох байгууллагын үйл хэрэгт ингээд бүүр хэвшүүлэх нэвтрүүлэх тухай дээр Засгийн газрын энэ төрийн байгууллагын үйл хэрэгт нэвтрүүлэх тухай дээр та дараа дараагийнхаа төр засгийн тэргүүнүүдэд ер нь юу гэж хэлмээр байна? Энийг би асууя гэж бодсон юм.

Ц.Сандаг-Очир: 3 номерын микрофон.

Г.Занданшатар: Ер нь иргэдийн оролцоог хангах чиглэлээр Засгийн газрын d_gov.mn, D_parliament.mn –тэй адилхан систем нэвтрүүлж улсын төсвийг анх удаа нийтдээ бараг 500 мянган санал авч, иргэдээр чөлөөтэй хэлэлцүүлж, И Монголиа хамгийн өндөр хэрэглээтэй болж санал авч өнгөрсөн. Энэ оны төсвийг буюу өнгөрсөн онд төсөв боловсруулж батлахдаа иргэдийн санал дээр тулгуурлаж эрүүл мэнд, боловсрол гээд салбаруудад эрэмбэлж ажилласан. Одоо яах вэ энэ Үндсэн хуулийн 6.2 дахь заалтыг бидний Улсын Их Хуралд ажиллаж байхдаа баталсан баялагтаа Эзэн Монгол байх, Байгалийн баялаг ард түмний мэдэлд төрийн хамгаалалтад байх үндсэн зарчимд нийцүүлсэн энэ заалтыг хэрэгжүүлэхээр Энержи Ресурс, Тавантолгойн бүлэг ордод үйл ажиллагаа явуулдаг Энержи Ресурс, Ханбогд эксплорэйшн, Нарийн сухайтын бүлэг ордын үйл ажиллагаа явуулдаг Өсөх зоос, Эрдэнэтийн үүсмэл ордын Ачит эх зэрэг компаниудын зарчмын тохиролцоо хийсний үр дүнд энэ оны 2 дугаар сарын 10-нд энэ 5 компанитай нийт өгөөжийн 60 хувийг Үндсэн хуулийн 6.2-т нийцүүлж өгөөжийн дийлэнх нь ард түмэнд оногдож байх зарчмыг давуулан биелүүлж 60 хувийг ард түмэнд өгөөжтэй болгох өгөөжийн хэмжээг жил бүр дүгнэж 60 хувиас буурсан тохиолдолд баялгийн татвар буюу нэмж өгөөж тохируулагч төлбөр татвар төлөх ийм зарчмын тохиролцоонд хүрч баримт бичигт гарын үсэг зурсан байгаа.

Энийг Улсын Их Хурлаар оруулж дээр нь ингээд нийтдээ 5 компани болж байгаа. Рио Тинто компанитай 5 асуудлаар шаардлага тавьж яриа хэлэлцээр амжилттай үргэлжилж байгаа. Ер нь нэлээн нааштай үр дүнгүүд явж байсан чинь одоогийн энэ улс төрийн гацаа үүссэн нь нэг талаар энийг ашигласан нь нэг энэнтэй ямар нэгэн байдлаар холбоотой гэсэн дүгнэлтийг хийхээс өөр аргагүй тийм нөхцөл байдлыг бас үүсгэж байна. Яагаад гэвэл хэлэлцээрийн явцад удаашрал үүсэж байгаа нь энэ улс төрийн тогтворгүй байдалтай холбоотой гэж үзэхээс аргагүй.

Нийтдээ 4 удаагийн хэлэлцээний баг ширээний ард суусан. Айлын тал тодорхой бууруулах саналууд өгсөн боловч бид санал нэгдээгүй байна. Монголын

тал өөрийнхөө байр суурин дээр хатуу байгаа. Ийм учраас хэлэлцээрийн хугацаа 7 жилд нэг удаа тохиолдож байгаа учраас бид бодит үр дүн гарахаар үндсэндээ урьдчилан тохиролцоод ер нь бас гоулд стрийминг форвард хэлцлүүдийн үр дүнд ноогдол ашгийг урьдчилгаа авахаар урьдчилан тохиролцъё гээд тодорхой ахиц үр дүнтэй явж байсан. Энэ хэлэлцээр бас жоохон хойшилж байгаад санаа зовж байгаа. Ер нь энэ хүрээнд бид зөвлөлдөх ардчиллын ард иргэдтэйгээ зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах шийдвэрийг өнгөрсөн оны 12 дугаар сард гаргаад бэлтгэл ажил хангагдаад Зөвлөлдөх зөвлөл байгуулаад энэ асуулга баялагтаа Монгол хүн бүр яаж эзэн нь байж энэ үр өгөөжийг хүртэж илүү оновчтой зарцуулах вэ гэдэг агуулгаар Үндэсний статистикийн газар, хараат бус судалгааны багууд ажиллаж энэ 4 сарын 10-нд нийт ард иргэдийг төлөөлж чадахуйц их олонлогоос сонгогдсон бага олонлог энэ Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсантай адилхан. Тэр баг хүмүүс тулалдаж бодлогын шийдвэрүүд дээр ажиллана. Хуулийн өөрчлөлтийн төслүүд дээр ажиллана. Ингэж илүү ард иргэдийнхээ оролцоотой баялагтаа эзэн байх зарчмыг хуульчлах ард иргэдийнхээ саналыг түлхүү тусгах ийм ажлыг Засгийн газраас зохион байгуулж байгаа.

Энэ ажил бол ард түмнийхээ саналыг сонсдог ардчиллын зарчмыг төлөөллийн ардчилалд учирч байгаа гажуудлуудыг засахад чиглэсэн ийм шинэлэг алхам болох төдийгүй Монгол хүн баялагтаа эзэн байх жинхэнэ утгаараа үр өгөөжийг нь хүртдэг байх, төр нь ил тод, шударга байх, оновчтой байх тэр зарчимд нийцүүлсэн хэлэлцүүлэг явагдаж энэ баялгийн сангийн менежмент баялгийн сангийн үр өгөөж тэр бусад агуулгуудыг илүү ард иргэддээ өгөөжтэй тэдний саналд тулгуурлаж боловсруулах ийм зарчмын асуудал хэлэлцэгдэх юм. Энэ дээр үндэслэж ард иргэдийнхээ санал дээр тулгуурлаад энэ санал дээр тулгуурлаад хуулийн төслийг Улсын Их Хуралд Үндэсний баялгийн сангийн хуульд өөрчлөлт оруулж өргөн барихаар төлөвлөж энэ санал асуулга хэлэлцүүлэг явагдана.

Ц.Сандаг-Очир: Болсон уу? Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Үг хэлэх гишүүн байна уу? Бямбацогт гишүүнээр тасаллаа. Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Тэгээд өнөөдөр Монгол Улсын Ерөнхий сайд Занданшатар бас өөрөө хүсээгүй. Өөр учир шалтгаан нөхцөл байдлын улмаас өргөдлөө өгч Монгол Улсын Ерөнхий сайдаас чөлөөлөгдөх гэж байна аа. Энэ Засгийн газар сайн ажилласан. Олон ажлуудыг хийж хэрэгжүүлсэн. Ямар нэгэн хууль зөрчсөн хулгай хийсэн зүйл байхгүй. Ямар нэг бас алдаа дутагдал гаргасан зүйл байхгүй. Эдийн засгийн өсөлт хасах руугаа орчихсон байх үед эдийн засгийн өсөлт 6.8 хувьтай болсон. Монгол Улсын валютын нөөц түүхэндээ байхгүй дээд хэмжээнд хүрч 7 тэрбум доллар болсон. Монгол Улсын зээлжих зэрэглэл 2012 оноос хойш хүрч байгаагүй бас өндөр түвшиндээ хүрч сүүлийн 12 жилийн хугацаанд хүрсэн. Эмч багш нарынхаа цалинг нэмэгдүүлсэн, хөрөнгө оруулалтууд хийсэн. Сая ярьж байгаа бүтээн байгуулалт, баялгийн өгөөжийг ард иргэддээ авчрах, баялагтаа эзэн Монгол байх энэ том бодлогын асуудлууд дээр 20 жил хийгдээгүй томоохон дэвслүүдийг хийж чадсан гээд ярих юм бол их олон зүйл хийж хэрэгжүүлсэн. Тэгээд Монголын түүх, цаг хугацаа, дээр нь бас цагаан дээр хараар бичсэн тоо баримтууд үүнийг бас нотлох байх аа.

Тийм болохоор харамсалтай байгаа. Тэгээд МАН-ын Удирдах зөвлөл хуралдаж МАН-ын Улсын Их Хурал бүлэг хуралдаж бас Ерөнхий сайдын бас

өргөдлийг хүлээж авах шийдвэр гаргасан. Тийм болохоор бас Ерөнхий сайдын гаргаж байгаа шийдвэрт бас хүндэтгэлтэй хандана аа.

Энд бас Засгийн газрын үйл ажиллагаа тасралтгүй явах ёстой. Өнөөдөр дэлхийн геополитикийн нөхцөл байдал маш амаргүй байна. Дэлхийг хамарсан газрын тос бензин шатахуунтай холбоотой маш том хямрал дэлхийн бүх улс оронд бас нүүрлэж байна. Монгол Улс үүнийг тойрч гарахгүй, дайраад гарна. Үүнийг дагасан бараа бүтээгдэхүүний суурь үнэд нөлөөлдөг бүх бараа бүтээгдэхүүнүүд үүнийн өсөлтөд нөлөөлдөг гол юм бол эрчим хүч, бензин шатахуун байдаг.

Тийм болохоор бас үүнийг дагасан томоохон хүндрэл бэрхшээл биднийг бас тун удахгүй нүүрлэх гэж байна. Энэ цаг үед бас сандал ширээтэйгээ зууралдалгүй хурдан хугацаанд шийдвэр гаргаж улс орныхоо эрх ашгийг 1 дүгээрт тавьж, эрх мэдэл, албан тушаалаа 1 дүгээрт тавилгүй хандаж байгаа Ерөнхий сайддаа бас талархаж байна аа. Тэгээд 1 горимын санал байгаа юм.

Үндсэн хуулийн 40 дүгээр зүйлд шинэ Ерөнхий сайд томилогдсоноор дараагийн шинэ дараагийн Ерөнхий сайдын бүрэн эрх дуусгавар болно оо гэж. Тийм болохоор Үндсэн хуулийн 40 дүгээр зүйлд энэ Засгийн газрын хуралдааны Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хугацаа нь Үндсэн хуулийн 40 дүгээр зүйлд заасан Засгийн газрын бүрэн эрхийн хугацаатай адил байх бөгөөд Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно гэсэн байгаа. Тийм болохоор чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээж авбал дараагийн шинэ Ерөнхий сайд томилогдох хүртэл хугацаанд Ерөнхий сайдыг бас үүрэг гүйцэтгэхээр ажиллуулах ийм асуудлаар дэгээр явах ёстой байх аа. Энийг бас Байнгын хороо бас анхаарч үзнэ үү гэсэн саналтай байна за.

Ц.Сандаг-Очир: Гишүүд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуулт асууж, үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Санал хураалтад бэлтгэе. Нэрсээ авчихсан болсон уу, санал хураалаа.

Томьёолол уншиж танилцуулъя. Болсон уу?

Саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарыг өөрийнх нь хүсэлтийг үндэслэн үүрэгт ажлаас чөлөөлөхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалтад 19 гишүүнээс 16 гишүүн дэмжиж, 84.2 хувиар санал дэмжигдлээ.

“Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулъя

Улсын Их Хурлын тогтоол

“Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай” Монгол Улсын үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 6 дахь заалт, 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 100 дугаар зүйлийн 100.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Ерөнхий сайдыг шинээр томилох хүртэл хугацаанд үүрэгт ажлаа гүйцэтгэж байхыг Гомбожавын Занданшатарт даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2026 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас чөлөөлөх асуудлыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн миний бие танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

20.10 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА